

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн  
аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/77/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/77/НА-СТА-ТШЗ

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн  
аудит

**АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
  2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
  3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
    - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
    - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
    - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
    - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
  4. Аудитын тайлан .....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
  6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн  
аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН  
17 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Х.ГҮЛЖАЙНА ТАНАА

2024.02.07 № 49  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд онцлох асуудал гараагүй байна.

**Аудитын гол асуудал**

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402060

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.АЙГҮЛ



Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6670000.00</b>	<b>113102050.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>3190000.00</b>	<b>94753305.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	3190000.00	94753305.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3480000.00</b>	<b>18348745.00</b>
35440	Түлш, шатах тослох материал	0.00	150000.00
35460	Хүнсний материал	3480000.00	9951745.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	8247000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>410871937.74</b>	<b>404429816.82</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>410871937.74</b>	<b>404429816.82</b>
391	Газар	0.00	0.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>395311937.74</b>	<b>387541460.42</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	440836198.00	440836198.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-51487177.74	-59179447.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19493700.00	13004000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-17391574.86	-8237857.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15865041.00	7257466.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13899507.66	-6138897.78
39217	Ном	1895259.00	0.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>15560000.00</b>	<b>16888356.40</b>
39301	Програм хангамж	660000.00	2083239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-660000.00	-754882.60
39303	Бусад биет бус хөрөнгө	15560000.00	15560000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>417541937.74</b>	<b>517531866.82</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>390034.00</b>	<b>0.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	390034.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>417151903.74</b>	<b>517531866.82</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>417151903.74</b>	<b>517531866.82</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	<b>15560000.00</b>	<b>15560000.00</b>
51101	Өмч: - төрийн	15560000.00	15560000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>401591903.74</b>	<b>501971866.82</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	401591903.74	401591903.74
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	100379963.08
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>417541937.74</b>	<b>517531866.82</b>

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>397,958,900.00</b>	<b>628,541,939.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>10,777,239.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	5,779,239.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	4,998,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>397,958,900.00</b>	<b>617,764,700.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>358,235,300.00</b>	<b>597,470,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	358,235,300.00	597,470,800.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>103,500.00</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>39,620,100.00</b>	<b>20,293,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,620,100.00	20,293,900.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>409,151,233.88</b>	<b>528,161,975.92</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>409,151,233.88</b>	<b>528,161,975.92</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>409,151,221.88</b>	<b>528,161,975.92</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>290,101,722.00</b>	<b>374,209,561.00</b>
210101	Үндсэн цалин	256,474,900.17	299,237,364.13
210102	Нэмэгдэл	26,762,910.38	60,828,987.82
210104	Урамшуулал	6,863,911.45	14,143,209.05
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,488,200.00</b>	<b>57,171,000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,811,900.00	38,876,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,919,100.00	4,573,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,335,200.00	3,659,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	583,800.00	914,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,838,200.00	9,147,600.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,443,800.00</b>	<b>18,743,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,652,147.00	3,565,006.00
210302	Түлш, халаалт	11,058,353.00	14,382,429.00
210303	Цэвэр, бохир ус	733,300.00	796,465.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>45,804,300.00</b>	<b>52,146,655.00</b>
210502	Хоол, хүнс	45,804,300.00	52,146,655.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>225,100.00</b>	<b>400,000.00</b>
210604	Урсгал засвар	225,100.00	400,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>814,000.00</b>	<b>999,600.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	999,600.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>21,274,099.88</b>	<b>24,491,259.92</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,356,700.00	7,771,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,572,800.00	3,798,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,344,599.88	12,921,359.92
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12.00</b>	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12.00	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(11,192,333.88)</b>	<b>100,379,963.08</b>
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(11,192,333.88)</b>	<b>100,379,963.08</b>

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>397958900.00</b>	<b>617764700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>358235300.00</b>	<b>597470800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	358235300.00	597470800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>103500.00</b>	<b>0.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103500.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>39620100.00</b>	<b>20293900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39620100.00	20293900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>394768900.00</b>	<b>525501395.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>394768900.00</b>	<b>525501395.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>394768888.00</b>	<b>525501395.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>289711688.00</b>	<b>374599595.00</b>
210101	Үндсэн цалин	239031691.25	274895146.01
210102	Нэмэгдэл	43816085.30	85561239.94
210104	Урамшуулал	6863911.45	14143209.05
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36488200.00</b>	<b>57171000.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	24811900.00	38876100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2919100.00	4573700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2335200.00	3659100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	583800.00	914500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5838200.00	9147600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14402100.00</b>	<b>18893900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2663747.00	3613900.00
210302	Түлш, халаалт	10938353.00	14480000.00
210303	Цэвэр, бохир ус	800000.00	800000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>103500.00</b>	<b>0.00</b>
210401	Бичиг хэрэг	103500.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>42344100.00</b>	<b>58618400.00</b>
210502	Хоол, хүнс	42344100.00	58618400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>500000.00</b>	<b>1400000.00</b>
210604	Урсгал засвар	500000.00	1400000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>814000.00</b>	<b>999600.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814000.00	999600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10405300.00</b>	<b>13818900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8905300.00	10820100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1500000.00	2998800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12.00</b>	<b>0.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12.00	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>3190000.00</b>	<b>92263305.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.00</b>	<b>700000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		700000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>-700000.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>3190000.00</b>	<b>91563305.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>3190000.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>3190000.00</b>	<b>94753305.00</b>

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	15,560,000.00		401,591,903.74		417,151,903.74
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,560,000.00	0.00	401,591,903.74	0.00	417,151,903.74
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,560,000.00	0.00	401,591,903.74	0.00	417,151,903.74
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	15,560,000.00	0.00	401,591,903.74	0.00	417,151,903.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,560,000.00	0.00	401,591,903.74	0.00	417,151,903.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			100,379,963.08		100,379,963.08
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,560,000.00	0.00	501,971,866.82	0.00	517,531,866.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	620954700.00	526201395.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	620954700.00	526201395.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	620954700.00	526201395.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	468589600.00	374599595.00
210101	Үндсэн цалин	312932500.00	273283875.00
210102	Нэмэгдэл	142263200.00	88854466.00
210104	Урамшуулал	13393900.00	12461254.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57934300.00	57171000.00
210201	Тэтгэврийн даатгал	39395100.00	38876100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4634800.00	4573700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3707900.00	3659100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	926800.00	914500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9269700.00	9147600.00

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>18893900.00</b>	<b>18893900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3613900.00	3613900.00
210302	Түлш, халаалт	14480000.00	14480000.00
210303	Цэвэр, бохир ус	800000.00	800000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>58618400.00</b>	<b>58618400.00</b>
210502	Хоол, хүнс	58618400.00	58618400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1400000.00</b>	<b>1400000.00</b>
210604	Урсгал засвар	1400000.00	1400000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>999600.00</b>	<b>999600.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	999600.00	999600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14518900.00</b>	<b>14518900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11520200.00	11520200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2998700.00	2998700.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>620954700.00</b>	<b>617764700.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>600660800.00</b>	<b>597470800.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	600660800.00	597470800.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>20293900.00</b>	<b>20293900.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	20293900.00	20293900.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>3190000.00</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>94753305.00</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>26.00</b>	<b>26.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгодог.

Байгууллагын зорилго:

Зорилго:

-Боловсролын хүртээмж чанарт ахиц гарган хүүхдийн хөгжлийг дэмжиж эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж ажиллах

Зорилт:

-Хамтран сургах, хүртээмжийг нэмэгдүүлэх

-Багшийн хөгжлийг дэмжих

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

## Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Сангийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 65 дугаар “хөтөлбөр батлах тухай” тушаал гарсан. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус цэцэрлэгийн 2023 оны үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99.9 сая төгрөгөөр буюу 123.9 хувиар өссөн байна.

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3190.0	94753.3	97943.3
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	3480.0	18348.7	14868.7
Үндсэн хөрөнгө	410871.9	404429.8	-6442.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>417541.9</b>	<b>517531.9</b>	<b>99990.0</b>
Өр төлбөр	390.0	0	-390.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	417151.9	517531.9	99990.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>417541.9</b>	<b>517531.9</b>	<b>99990.0</b>

Оны эхэнд мөнгөн хөрөнгө 3.2 сая ба оны эцэст их хэмжээний буюу 94.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 94.7 сая төгрөг цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс үлдсэн байна.

Бараа материал дансны эхний үлдэгдэл 3.5 сая төгрөг ба оны эцэст 18.3 сая төгрөг болж 14.8 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: хүнсний материалын үлдэгдэл 9.9 сая төгрөг, бусад хангамжийн материал 8.2 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 404.4 сая төгрөг болж 6.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 5.8 сая төгрөгөөр нэмэгдэж 12.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 517.5 сая төгрөг болж 99.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 100.4 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 336.5 сая, орон нутгийн төсвөөс 16.2 сая, нийт зарлагыг 352.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 458.4 сая төгрөгөөр хянаж, 121.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба төсвийн тодотголоор 139.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 597.5 сая төгрөг болгон тодотгож баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 16.2 сая төгрөгөөр баталж, тодотголоор 4.1 сая төгрөгөөр нэмж 20.3 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 597.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 20.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 617.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 597.5 сая, орон нутгийн төсвөөс 20.3 сая нийтдээ 617.8 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 526.2 сая төгрөг буюу 85.2 хувьтай буюу дансанд 94.7 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах

## Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д		Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	1499.4	1499.4	0	100%
2	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	58618.4	58618.4	0	100%
3	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3123.7	3123.7	0	100%
4	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1499.9	1499.9	0	100%
5	81834	Боловсролын стандарт, сургалтын	345976.7	265189.6	80787.1	76.6%
6	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	189943.2	175977.0	13966.2	92.6%
7	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	20293.9	20293.9	0	100%
		<b>Нийт дүн</b>	<b>620955.2</b>	<b>526201.0</b>	<b>94753.3</b>	<b>84.7</b>

Төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 94.7 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардал 93.9 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 0.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 0.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 80.8 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

## Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний аудитор В.Хуандых гүйцэтгэж, анхан шатны хяналтыг “Уужим алтай Аудит” захирал Б.Галымбек, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардал сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 409.1 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 8.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

## Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 5.9 сая төгрөгийн 14 шийдвэрийг мэдээлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай холбоотой албан шаардлага өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	5900.0	1	5900.0	100%
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>5900.0</b>	<b>1</b>	<b>5900.0</b>	<b>100%</b>

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 17.9 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч, 5.4 сая төгрөгийн албан шаардлага, 12.5 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчилд албан шаардлага өгөгдлөө. Үүнд:

1.Баян-Өлгий аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 130/ШШ2022/00884 дүгээр шүүгчийн захирамжаар туслах багшийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 5.4 сая төгрөгийг цэцэрлэгийн төсвөөс

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

олгохоор шийдвэрлэсний дагуу цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн Б/26 тушаалаар туслах багшид ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 5,433.5 мянган төгрөгийг цэцэрлэгийн төсвөөс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дансанд шилжүүлэн барагдуулж, төсөвт тусгагдаагүй зориулалт бусаар зардал гаргасан байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### Шийдвэрлэсэн нь:

Цэцэрлэгийн туслах багшид ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт төсвөөс төлсөн 5.4 сая төгрөгийг нөхөн төлүүлж төсвийн орлогод оруулах талаар албан шаардлага өгөгдлөө.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### 1.1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 12.5 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах.

*Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	12,500.0					1	12,500.0			
Цалингийн зардалаас төсөвт тусгагдаагүй зориулалт бусаар зардал гаргасан	1	5,433.5			1	5,433.5						
Дүн	2	17933.5			1	5,433.5	1	12500,0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								